



112

## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2006 оны 6 сарын 21 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

### Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх заалт, нийслэлийн Засаг даргын өргөн баьсан саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийн асуудлыг хариуцан гүйцэтгүүлэхээр Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн дунд "Багачууд хүнс", Баянзүрх, Хан-Уул дүүргийн дунд "Өсвөр үе хүнс", Баянгол, Сонгинохайрхан дүүргийн дунд "Асгат" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2006 оны 7 дугаар сарын 1-нээс байгуулсугай.

Хоёр.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийн чанарын байдалд тавих мэргэжлийн болон хөндлөнгийн хяналтын тогтолцоо бий болгох асуудлыг шийдвэрлэхийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Ц.Батбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 45, 68 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.



ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД:

*Балормаа*

Н.БОЛОРМАА

*Д.Баасансүрэн*

Д.БААСАНСҮРЭН

*Ш.Алтангэрэл*

Ш.АЛТАНГЭРЭЛ

*Я.Аюушжав*

Я.АЮУШЖАВ

*С.Баярмөнх*

С.БАЯРМӨНХ

*Т.Билэгт*

Т.БИЛЭГТ

*Г.Мөнхбаяр*

Г.МӨНХБАЯР

*С.Отгонбат*

С.ОТГОНБАТ

*Б.Ундармаа*

Б.УНДАРМАА

My.Doc.Togtool2

0100578